

## **ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАРИФ ТОГТООХ АРГАЧЛАЛ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Харилцаа холбооны үйлчилгээний тарифыг тогтоохдоо энэхүү аргачлалыг мөрдлөгө болгоно.

1.2 Харилцаа холбооны зах зээл дээрхи үйлчлэгч нар нь өөрийн үйлчилгээний тарифыг тогтоохдоо

ОУЦХБ-аас гаргасан зөвлөмж болон дэлхийн эдийн засаг, хамтын ажиллагааны байгууллага, дэлхийн худалдааны байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн дараах аргачлалуудаас өөрийн үйлчилгээний онцлог байдалд тохируулан ашиглана.

Үүнд:

- А. Өртөг, хөрөнгө оруулалтын өгөөжийн түвшинд үндэслэх зарчим
- Б. Үнийн хязгаар тогтоох зарчим
- В. Үнийн харьцуулалт хийх зарчим

### **Хоёр. Үйлчилгээний тарифыг тогтоох аргачлал**

#### **Өртөг, хөрөнгө оруулалтын өгөөжид үндэслэх арга**

Аливаа үйлчилгээний тариф нь тухайн үйлчилгээг явуулахтай холбогдон гарах зардал, тухайн үйлчилгээнд оруулсан хөрөнгө оруулалтыг тодорхой хугаацаны дараа бүрэн нөхөж дахин хөрөнгө оруулалт хийх хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх хэмжээний ашгийг шингээсэн байна.

$$T = \Theta + A$$

T- нэгж үйлчилгээний тариф

Θ- нэгж үйлчилгээний өртөг

A- нэгж үйлчилгээний ашгийн хэмжээ

Үйлчилгээний өртөг (Ө) нь тухайн үйлчилгээнд ноогдох ашиглалт үйлчилгээний зардлыг тухайн үйлчилгээний хэмжээнд харьцуулсан харьцаагаар тодорхойлогдоно.

Өртгйн хуваарилалтыг байгууллагын санхүүгийн тэнцэл, орлого зардал, үр ашиг, мөнгөний урсгалын тайлан болон үйлчилгээний тоо хэмжээний статистик тэдээг үндэслэн тооцно.

Өртгийн хуваарилалтыг хийхдээ дараах тооцоонуудыг нарийвчилан хийх шаардлагатай. Үүнд:

- Байгууллагын хөрөнгийн ангилалыг тогтоох
- Хөрөнгийн ангиллын дагуу зардлыг тооцох
- Хөрөнгө оруулалтын өгөөжийн хувийг тооцох
- Ашиглалтын нийт зардлыг тодорхойлох
- Ашиглалтын нийт зардлыг үйлчилгээ тус бүрт хуваарилах

Нэгж үйлчилгээнд шингээх ашгийн хэмжээ (А)-г тухайн байгууллагын тайлант оны нэгж үйлчилгээнээс олсон ашгийн хэмжээнээс хэтрэхгүй байх зарчмыг баримтлан тогтооно.

Цахилгаан холбооны үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудын хувьд ОУЦХБ-аас зөвлөмж болгон гаргасан цахилгаан холбооны үйлчилгээний өртөг, тарифыг тооцох аргачлалыг ашиглан тооцоолон гаргаж болно.

### **Үнийн хязгаар тогтоох арга**

Зах зээлийн өрсөлдөөний байдалд зохицуулан өртгөөсөө доогуур тарифыг тогтоон тодорхой хугацааны дараа өртөгт хүргэх зорилго тавьж байгаа бол үнийн хязгаар тогтоох аргаар тарифыг тогтоож болно.

Энэ аргыг ерөнхийд нь томъёолбол:

$$T_t = T_{t-1} \times \Delta I$$

$T_t$  – Тухайн жилийн тариф

$T_{t-1}$  – Урьд нь мөрдөгдөж байсан тариф

$\Delta I$ - Тухайн жилийн үнийн хязгаарын индексийн өсөлт, бууралт

$$\Delta I \leq \text{ЖХБИ} - X$$

ЖХБИ- жижиглэн худалдаалах бараа үнийн индекс буюу инфляци

$$X = (\Theta X_{xx} - \Theta X_{ynb}) \pm 3$$

X - үр ашгийн тооцоологдсон өсөлт

$\Theta X_{xx}$  - харилцаа холбооны салбарын үр ашигийн өсөлтийн хувь / тухайн байгууллагын үр ашигийн өсөлтийн хувь байж болно./

Энэ үзүүлэлт нь техник технологийн шинэчлэлт өөрчлөлтийн хурдац, тухайн үйлчлэгчийн санхүүгийн байдлаас хамаарна.

$\Theta X_{yn6}$  – үндэсний нийт бүтээгдэхүүний үр ашгийн өсөлтийн хувь / эрх бүхий байгууллагаас тогтоон зарладаг /

3 – тухайн үйлчилгээнд зайлшгүй гарах зардлын өсөлт бууралтын хувь

Үнийн хязгаар тогтоох аргаар тарифыг тогтоохдоо одоогийн мөрдөж байгаа тарифыг тухайн үеийн инфляцийн түвшингээс нэмэгдүүлэхгүйгээр тооцдог. Гэхдээ үнийн хязгаар тогтоох хугацааны хувьд 3-5 жил байх нь оновчтой бөгөөд тодорхой хугацааны дараа тарифыг өртөгт хүргэх нөхцөл бүрдүүлэх сайн талтай.

Үнийн хязгаарыг үйлчилгээ тус бүр дээр тогтооход хүндрэлтэй бол үйлчилгээг төрөлжүүлэн багцалж үнийн хязгаарыг тогтоож болно.

### **Үнийн харьцуулалт хийх арга**

Энэ аргаар үйлчилгээний тарифыг тогтоохдоо ижил төрлийн үйлчилгээ эрхлэгчийн үйлчилгээний тарифтай харьцуулалт хийсний үндсэн дээр өөрийн орны зах зээлийн нөхцөлд тохирсон тарифыг тогтооно.

Үнийн харьцуулалт хийх аргыг шинээр эрхлэх үйлчилгээний тогтооход ашиглах нь илүү тохиромжтой.

### **Гурав.Үйлчилгээний тарифыг тогтооход баримтлах үндсэн зарчмууд**

1. Тухайн үйлчилгээний тариф нь үйлчилгээний чанар, хэрэглэгчдийн эрх ашигт нийцсэн байх
2. Хэрэглэгчдийн төлбөрийн чадварт тохирсон уян хатан байх
3. Тариф нь шударга бус аргаар зах зээлээс ижил төрлийн үйлчлэгчийг гаргах зорилго агуулаагүй байх
4. Хэрэглэгчдэд үзүүлэх ижил төрлийн үйлчилгээнд ялгавартай үнэ тогтоохгүй байх
5. Тариф нь төгрөгний ханшийн өөрчлөлттэй уялдан зохицсон байх